

**ЦУУРЫН ҮҮСЛИЙН ТАЛААР ХЯТАДЫН СУРВАЛЖ БИЧИГТ
ТЭМДЭГЛЭГДСЭНИЙГ АЖВАЛ...**

Л. Хэрлэн *

Хөөмэйн талаар тэмдэглэгдсэн түүхийн сурвалж материал хомс боловч Хятадын сурвалж бичгүүдэд дурьдсан зарим материалаас иш татан хөөмэйн үүссэн цаг хугацааг бага боловч тодорхойлох оролдлого гаргаж болмоор байна.

Өвөрмонголын Шинжианы Их сургуулийн доктор, професор Ф.Мэргэжих цуурын талаар бичсэн хэд хэдэн өгүүлэлдээ Алтайн болон Өвөрмонголын цуурын талаар бичиж, Алтайн цуурыг хоолойн цуур, модон цуур гэж ангилаж хоолойн цууртаа хөөмэйг, модон цууртаа үлээвэр хөгжимтэй хамтатган авч үзсэн байна. Түүний өгүүлж байгаагаар дууны ая бүтэц хэлбэрийг нь хийн өгүүлбэр, цуурын ая, уртын дууны хэлбэр, тусгай хөгжмийн ая гэх мэтчилэн ангилснаас үзвэл цуур гэдэг нэр томъёондоо хүний өгүүлэх эрхтэнээр үйлдэгдэж буй хөгжимдөх арга барил, хэлбэрүүдийг зааж “хоолойн цуурыг нэг хүн ганцхан хоолой дотроос хоёр зүйлийн дуу үүсгэхийг хэлнэ” гээд модон цууртаа өнөөдөр монголчуудын дунд өвлөгдөж ирсэн модон цуур хөгжмийг заасан байна. Тэрээр хоолойн цуураа “монгол дууны хоршил дуулах арга” гэж нэрлээд алтайн цуур нь монгол хөгжимдүүрийн өвөг үүслийн эх гэх зэргээр бичсэн байна. Эдгээр нэр хэллэгүүдтэй нэн тохирох түүхэн баримт бол Хятадын түүхэн сурвалж бичиг баримт болох “Шиаогийн магт дуу” юм.

Тэрхүү тэмдэглэлд: “Хятадын Чүн-чиүгийн үеийн Жинь улсын Чэн Гүн шиаогийн хөгжмийг сонсож нэг бадаг “Шиаогийнмагтдуу” бичив” гэжээ.

“...Уран эгшиг улаан уруулаас үүсэж
Уяраан дуун цагаан шүднээс гармуй
Цуурай ану тунгалаг бөгөөд ээвэргүү
Цог ану цэлгэр бөгөөд дүрэлжүүн
Гундагуунытунгалагааржидугууныг тодруулан
Шандууны цээлхэнийгжидуун дур найржухуй
Шилжих үүлийг агаар мандал дур дэгдээгээд
Ширүүн салхийг түмэн газраас хуруйлмуй
Шимт бодьгалийн туйлын эгшиг буй за
Ширхэг хулсны дуун бус ажгуу
Тийнхүү дууныг зэмсэг дур түшихгүй
Эд хэрэглэл дор найдахгүй

* Монгол Улсын Их Сургууль

Дөхөм дөт биеэсээ авч
 Сэтгэлийг зарж, амьсгал хэрэглэж
 Уруул хөдөлгөөөөс аялгуу болж
 Ам нээвээс дуун үүсэж
 Юмыг үзэн бодис дур ягтлан
 Дуун аяар исгэрэл дагаж
 Бялар бишгүүрээс яруу тунгалаг
 Ятга ширхэгээс уяхан цээлхэн
 Хүрхрэн шуугих салхи үүсэж
 Янцгаан үүрсэх дуун гарах ану
 Ар газрын хөлөг морьд
 Нутаг юугаа мөрөөдөж
 Хүйтэн салхинаа
 Умарш хандан үүрсэх мэт..."
 "...Хун галуу өндөр дуунаар ганганан
 Олон шувууд говь цөл дур жиргэх адил
 Тийнхүү дүрсийг үзээд дуун үүсэж
 Хэрэг тур игтэлж аялгуу бүтээмүй"¹ гэжээ.

Энэхүү түүхэн тэмдэглэлээс “Хүрхрэн шуугих салхи үүсэж, янцгаан үүрсэх дуун гарах ану ар газрын хөлөг морьд нутаг юугаа мөрөөдөж, хүйтэн салхинаа **умарш** хандан үүрсэх мэт” гэсэн нь Еберхардын “Магадгүй бас шиао нь хятад бус умар зүгийн гаралтай хөгжмийн зэмсэг байсан байж болно” гэдэгтэй таарч байх төдийгүй Хятадын хойд нутгаар нутагладаг үндэстний дунд нилээд түгээмэл хэрэглэгдэж байсан “**шиао**” хэмээх хөгжмийн зэмсгийн дуурьслын талаар өгүүлсэн байж болох юм.

“Шаиогийн магт дуу”-нд өгүүлснээр: “Уран эгшиг улаан уруулаас үүсэж, уяраан дуун цагаан шүднээс гармуй, **ширхэг хулсны дуун бус ажгуу**, цуурай ану тунгалаг бөгөөд зөвэргүү, цог ану цэлгэр бөгөөд дүрэлжүүн” гэсэн нь хүний өгүүлэхүйн эрхтэнээс гарч буй эгшиг авиаг тэмдэглэсэн бол “**дууныг зэмсэг дур түшихгүй**, эд хэрэглэл дор найдахгүй” гэсэн нь ямар нэгэн хөгжмийн зэмсгээр үйлдэгдэхгүйг нэрлэжээ. Цааш нь: “дөхөм дөт биеэсээ авч, сэтгэлийг зарж, амьсгал хэрэглэж уруул хөдөлгөөнөөс аялгуу болж, ам нээвээс дуун үүсэж, юмыг үзэн бодис дур ягтлан, дуун аяар исгэрэл дагаж, бялар бишгүүрээс яруу тунгалаг, ятга ширхэгээс уяхан цээлхэн” гэсэн нь хөөмэйн дуугаралт, эгшиглэлтийг тэмдэглэжээ. “Шаиогийн магт дуу” -г “Цуурын магт дуу” хэмээн орчуулсан орчуулгын бүтэн эх нь бидэнд эх материалаараа бус нэгээхэн хэсэг нь байгаагаас олж үзсэн юм. Түүнээс ажиглан үзвэл энд өгүүлэгдэж буй зүйл нь цуур хөгжмийг биш харин хөөмэйн эгшиглэлийг хэлсэн байж болох талтай. Магадгүй бидэнд олдсон эл хэсэг нь хөөмэйн тухай таарсан байж болох ч ерөнхийдөө эх материал нь цуурын тухай өгүүлснийг үгүйсгэж болохгүй. Цуур хөгжим нь өөрөө хөөмэйн урлагтай холбоотой учраас цуур хөөмэй хоёрыг уялдуулан авч үзэж болохыг үгүйсгэх үндэслэлгүй. Цааш тэрхүү тэмдэглэлд: “гундагуунытунгалагааржидугууныг тодруулан, шандууны цээлхэнийгжидуун дур найржухуй” гэснээс хөөмэйн дуугарах багтаамж, хөг аялгууг бас өгүүлсэн гэж үзэж болно.

¹ Мэргэших Ф. (1998), “Цоорын үзэгдэл болон цоорын хөгжим”, Шанхайн Хөгжмийн Дээд Сургуулийн ЭШсэтгүүл, №2, 4 тал, Мөн Л.Эрдэнэчимэг, “Түн гэрийн хатагтайн” нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу” УБ., 98-р тал.

Хятадын Жинь улс нь МЭ 265- МЭ 420 он² тоололд хамрагдах бөгөөд Хан улсын түүхэн бичигүүдэд: “Жинь ян хот хуугийн морьт цэрэг дур олон давхар бүслэгдээд, хотын дотор бачимдаж ядахуйдаа күн сарны гэрэл дур асар дээр гарч шяо дуугаргавай. Дээрэмчид сонсоод гаслантайгаар урт сүүрс алджихуй шөнө дөлөөр Хуугийн цоорыг хөгжимдөхүй дор дээрэмчид уйлж, эх нутгаа санжухуй. Үүрээр дахин үлээхүй дур дээрэмчид бүслэлтээ хаяж очвой”³ гэснээс мөн умардын дээрэмчид өөрийнхөө нутгийнхаа шиао хөгжмийг сонсоод тэсгэлгүй нутгаа санаж бүслэлтээ хаяж явсныг бас гэрчилдэг.

Өвөрмонголын их сургуулийн доктор, профессор Ф.Мэргэжих шиаог “цуур”⁴ гэж тэмдэглэсэн байдаг бол урлаг судлаач, хэл шинжээч Ж.Бадраа шиаог бишгүүр болон чавхдаст хуур хөгжимтэй холбон тайлбарласан нь бий. Тухайлбал: “шиао гэдэг нэртэй нэгэн зүйл үлээвэр хөгжмийн зэмсгийг Солонгост хучин гэж байсан гэж Еберхард мэдээлэлд: шиао чухамдаа “сумны зэв” гэсэн утгатай. Энэ нь Хүннүгийн “дуут сумыг” арга буюу санагдуулж байна. Магадгүй бас шиао нь хятад бус умар зүгийн гаралтай хөгжмийн зэмсэг байсан байж болно” гэсэн бол Ж.Бадраа: “шиаог монголоор бишгүүр “хисгэр, исгэр” гэдэг үгтэй холбоотой. Монголын цуур гэдэг үг дан ганц үлээвэр хөгжмийн нэр биш, мөн чавхдас хөгжмийн зэмсгийн нэр байсан. Жишээлбэл, саяхан болтол одоогийн Баянхонгор аймгийн ард олны хэрэглэж байсан янгирын шөрмөсөөр хийсэн зургаан чавхдастай жижигхэн ятгыг “шөрмөсөн цуур” гэдэг байсан” гэжээ. Цааш нь: А.Д.Руднеев “Дорнод монголын аман аялгууны хэрэглэгдэхүүн” гэдэг номондоо: “жастуу аялгуугаар “шоор” гэж хоёр чавхдастай хийл, хоороос ялгаатай нь нум нь чавхдасныхаа хоорондуур ордоггүй, чавхдасы нь чөрмөсөөр биш хялгасаар хийдэг” гэж мэдээлсэн “тэдний шоор гэдэг морин хуурын нэр ажээ. Энэ шоор гэж байгаа нь цуур гэдгийн авиалбарын хувилбар болох нь мэдээж” гээд мөн Тан Улсын Хятадад бас хоёр ихэр хөгжмийн зэмсэг бийбаагийн загвараар үйлдээд “дахулэй, шиаохулэй” буюу их хуур, бага хуур гэж нэрлэжээ, энэ мэтчилэн хөгжмийн зэмсгийн нэр эрт цагаас өөр өөр төрлийн хөгжмийн зэмсэгт шилжиж байсан”⁵ гэж тэмдэглэсэн нь бий.

Дээрх Ж. Бадраа гуайн тайлбараар шиао-г хуур, чавхдас хөгжмийг нэрлэж байсан бус харин цуур гэдэг нэр томъёонд нутаг нутагт олон хөгжмийн зэмсгүүдийг нэрлэж байсан байж болох талтай. Мөн А.Д.Руднеевжастуу аялгуугаар “шоор” гэж нумт хөгжмийн нэгэн төрлийг нэрлэсэн нь Ж. Бадраагийн хөгжмийн ерөнхий нэр томъёонд багтаж нэрлэсэн бололтой. Жастуу аялгуу нь “Өвөр монголын Хянган аймгийн Дөрвөд бэйсийн хошууны Жасты чуулганы аман аялгуу”⁶ -нд багтах бөгөөд шоор гэдэг нь үндсэндээ цоорыг нэрлэж байгаа нэр томъёо юм. Учир нь уугуул нутгийн хэллэгээр “ц” үсгийг “ш”-ээр дуудаж (цамц-шамш, цагаан-шагаан, цус-шут, цуу-шуу гэх зэргээр) нэрлэдэг.

Хятадын сурвалж бичгүүдээс иш татан шяогийн талаар тэмдэглэглэл дээр үндэслэн хөөмэйн үүслийн цаг хугацааг МЭӨ 3000 жилийн өмнөх II хагасаас түүхэнд

² “Хятадын хөгжмийн зэмсэг”, 56, “Монгол дуу хөгжмийн судлал” Шинжъяан, 1997, 70, 92, 161, 190, 342-р талууд

³ Гэрэлт Э. “Хөөмэйн урлагийн үүсэл, тархалт” Өвөрмонголын Их Сургуулийн ЭШБ, 2003,

⁴ Мэргэших Ф. “Хоолойн цуурын нууц” /“Талын дуулал” сэтгүүл, Хөх хот, 1986, №6, “Цоорын үзэгдэл болон цоорын хөгжим” Шанхайн Хөгжмийн Дээд Сургуулийн ЭШБ, 1998, №1

⁵ Бадраа Ж. (1998), “Монгол ардын хөгжим” УБ, 92-93-р тал

⁶ Г.Гантогтохын тайлбар /Хэл шинжлэлийн ухааны доктор /Sc.D/, 2005:11:22

тэмдэглэгдсэн Ази тивийн эртний нүүдэлчин аймаг Хүннү нарын дунд хэрэглэгдэж байсан олон хөгжмийн зэмсэг дотор цуур байсан ба мөн түүгээр тоглох арга барилын үндэс хөөмэйгээр дуулж байсан гэж үзэж боломоор байна. Цуурын талаар мөн Хүннү нарын хөгжим байсан гэдэг тодотголд:

“...Цуур гэдэг хөгжим
Ху-гийн голомтоос үүсэлтэй
Чавхдах ятгын эгшиглэн
Цуурын эгшигт ерөөлтэй...”⁷

гэж Хятадын нэгэн хатан Хүннү нарт баригдан тэнд арав гаруй жил амьдарч, тэр тухай бичсэн нэгэн түүхэн сударт тэмдэглэснээр бас тодорхойлож болно.

Хятадын Хан улсын үе Монголчуудын өвөг болох Хүннү улсын үед монгол газар олон зүйлийн хөгжмийн зэмсэг хэрэглэж байсан тухай Хятадын аман яриа, бичиг зохиолоор уламжлагдан ирсэн тухай өөр нэгэн сонирхолтой баримтанд: “Хятадын Хан улсын хоёр цэрэг Ли-лин, Сү-ү нар Хүннүчүүдэд баригдан харь нутагт цөллөгджээ. Ли-лин нь Енисей мөрөн, Абакан гол орчим нутагт, Сү-ү нь Байгаль далайн дэргэд нутаг заагдан 19 жил ямаа хариулж байжээ. Ли-лингийн захидалд: “Намар хүйтэн болоод шөнөд даарч байхад хүннү цэргийн бүрээ, адуу янцгаах сонсогдоно. Шөнө турш ийш, тийш хөрвөөн хэвтэхэд аяндаа нулимс урсана... Шөнөдөө хүннүгийн хөдөө хязгаарт суухад үргэлж хүннү цэргийн бүрээний дуу чихнээ ороод, зүрхийг минь имчнээ”⁸ гэсэн нэгэн баримт байхад Сү-үгийн дуу гэж одоо болтол монгол, хятадын аман бичигт уламжлагдан ирсэн байдаг байна. Энэхүү түүхийн сурвалж бичигт дурдсанаар Ху нарын хэрэглэж байсан “цэргийн бүрээ” гэсэн мэдээллийг зарим урлаг судлаачид “дуу хөгжим”⁹ гэсэн арай өргөн утгаар авч тайлбарласан нь ч бий.

Энэхүү таамаглалд үндэслэл болгон ашиглаж болмоор нэгэн сонирхолтой баримт байгааг өгүүлбээс баруун монголын алдарт цуурч П.Наранцогтын байгалийн чулууг ашиглан цуурдах маягаар үлээж ая аялгуу оруулж байсан явдал болно. Энэ талаар С.Дулам: “Цуурч П.Наранцогт эл бүх аялгууг гаднаас жижиг чулуу түүж авчиран цуурдаж үзүүлж байснаас гадна, хуруугаараа юм уу хатуу цаасаар орлуулан цуурдаж байсан нь цуурын анх гарлын тухай сонирхолтой санаа төрүүлсэн юм. Энэ цуурчийн хуучилснаар бол эртний монгол цэргүүд дайн тулалдаанд орохдоо газраас жижиг чулуу түүн авч нэгэн зэрэг цуурын уриа татдагаараа их алдартай байсан гэсэн билээ.”¹⁰

Үүнээс үндэслэн Монголчуудын өвөг Хүннүчүүд уриа дуудлагаа байгалийн элдэв бодит зүйл чулууг ашиглан уриа дуудлага татан дуудах болсон нь цуурын анхны хэлбэр байсан байна. Хөгжим үүсэж бий болох хөгжлийн явцад цуурын эгшиг авиа нь уриа дуудлагын хэлбэртэй байснаа хөгжмийн хөгжлийн явцад улам боловсронгуй болж цуур хөгжим нь биеэ даасан хөгжмийн зэмсгийн төрөл болох тэр явцдаа хөөмэйн эгшиг авиаг хамсруулан хүний өгүүлэх эртнийг дээд зэргээр хөгжүүлэн баяжуулах явц эрт үеэс монголчуудын дунд боловсорсон нь гайхамшигтай. Цуурыг монголчуудын дунд эртний хал хөгжим хэмээн үздэг хэдий ч өвөр монголчуудын зарим нутаг хорчин,

⁷ Эрдэнэчимэг Л. (2002), “Түн гэрийн хатагтайн” нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу”, УБ., 116-р тал

⁸ Содном Б. (1960), “Монгол дууны түүхээс” УБ., 6-р тал

⁹ Содном Б. (1960) “Монгол дууны түүхээс” УБ., 6 дахь тал, Дашдорж Д. (1971) “Ардын хөгжмийн суу билэгтнүүд” УБ., 8-р тал, Оюунчимэг Л. (1995) “Шударгын арван найман ая хөг” УБ., 12-р тал

¹⁰ Дулам С. (1989), “Монгол домог зүйн дүр” УБ., 157-р тал

шинжяны зарим угсаатан морин хуурын зарим төрөл болох хөгжим мөн хоолойн эрхтэнээр дуугарах зарим нэг төрөл элементүүдийг ийнхүү бас нэрлэдэг байна.

Цуур нь бусад хөгжим тэр дундаа үлээвэр хөгжмөөс онцлох ялгаа нь хүний өгүүлэх эрхтнээр үйлдэгдэх хөгжлийн дээд шат хөөмэйн урлагтай холбогддогоороо онцлог. Өөрөөр хэлбэл хөөмэйн исгэрээ, хархирааны суурь өнгөн дээр цуурын аялгууг гаргаж тоглодогоороо онцлог юм.

Тэгвэл дээрхи Хятадын түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн “Шиаогийнмагтдуу” гэдэг зохиол нь монголчуудын эртний нэгэн хөгжмийн зэмсэг болох цуур түүгээр тоглогдох үндсэн арга болох хөөмэйн эгшиглэлийн холбогдолын талаар өгүүлжээ гэж үзэж болмоор байна.

Шиаог Хятад хэлний толь бичигт: *Нэг дэх утга нь:*

- хүнээс гарах дуу авиа, исгэрэх, хархирах
- адгуусан амьтнаас гарах авиа, барс хархирах, адгуус дуугарах, шувуу жиргэх
- байгалийн чимээ, салхины исгэрээ
- техникийн дуу чимээ, машин, онгоцноос гарах исгэрээ¹¹

гэж тайлбарласан бол *хоёр дахь утга нь:* “Ху-гийн нэгэн зүйл үлээвэр хөгжмийн зэмсэг, эрт үед олон хулсыг зэрэгцүүлэн үлээдэг байсан бол одоо үед ганцаар нь үлээх болсон”¹² гэжээ. Шиао мөн хуу жиа гэж хятадын толь бичгүүдэд модон цоор гэж тэмдэглэсэн нь бий.

Хүн, адгуус, байгаль, техникээс гарах ямарваа исгэрэх дуу чимээ, авиаг нэрлэсэн шяогийнталаархидээрхи утга тайлбар нь Еберхардын: “шиао чухамдаа “сумны зэв” гэсэн утгатай. Хүннүгийн “дуут сумыг” арга буюу санагдуулж байна” гэдэг тайлбартай утга нэг байна.

Аливаа байгаль, эд зүйлс, амьтнаас гарах дуу чимээг дууриан хүн анх хөгжмийн зэмсэг мөн дуу үүссэн гэх нотолгоог олон эрдэмтэд дэвшүүлэн тавьдаг. Хүн анд гарах, анхныхаа анг агнасан сэтгэлээ илэрхийлэн гаргахдаа янз бүрийн хөдөлгөөн хийх болсноор бүжиг, отог омгийнхоо гал манан шөнөжин суух зуураа ая аялгуу гиншин дуугарах болсноор дуу үүсэн гэдэг таамаглалыг дэвшүүлэн тавьсан байдаг. Хүн ан агнах гэж ангаа отож суун андаа нум сум тавих агшинд гарсан нумнаас гарах чимээ, авианаас хөгжмийн эгшиг гаргах анхны санаа гарч, магадгүй чадхдаст болон утаст хөгжим үүссэн байж болхыг үгүйсгэх аргагүй.

Мөн Хан улсын судар бичигт тэмдэглэгдсэнээр “Тайшийн хоёрдугаар он МТӨ 95 он) баруун орон дор Ин шяо улс амуй, хүмүүс шиао дур мэргэшээд, эрчүүдийн шяо зуун газар сонстмуй. Бялар бишгүүрийн аялгуу мэт, намар өвөл болбоос дуун ану нам дор. Хэлний үзүүр ану хоолой уруу матарч бас хэлний хоршил аялгуу хэмээмой” гэснээс шиао гэдэг нь хөөмэйгээр дуулах үйлдлийг заахаас гадна дээрхи Хятадын Жинь (МЭ265-МЭ420) улсаас өмнө Хан улсын үед Хятадын хөрш зэргэлдээх Ин шяо оронд хөөмөйлдэг байсныг илтгэж байна. Тайширийн хоёрдугаар он МТӨ 95 гэснээс хөөж үзвэл Хятадын түүхэнд Хан улс нь МЭӨ 206- МЭ 220 оны хооронд оршин тогтнож байсан ба дээрхи түүхэн тэмдэглэл нь Зүүн Хан улс МЭ 25-МЭ420 онд хамаарагдаж байгаатай тохирч байна. Энэ нь Зүүн Хятадаас баруунд орших үндэстэн хөөмэйгээр хөөмөйлж байсныг илтгэж байна.

¹¹ “Хятадын одоо шүийн толь бичиг” Шинжъяан, 1978, №1, 1273-р тал.

¹² Мөн тэнд 1265-р тал

Тиймээс Оросын археологич Ванштейны “Алтай Монголын соёл дорно тийш хөгжсөн нь” гэдэг өгүүлэлдээ: “хөөмэйн урлагийн үүсэл нь Монгол, Алтайн сав газраас гаралтай бөгөөд эндээс тархаж хөгжсөн” гэдэгтэй санал нэг байна.

Монголчуудын үндэсний хөгжмийн зэмсгийн үүсэл манай эртний өвөг болох Хүннүчүүдийн дунд хөгжмийн зэмсгийн төрлүүд нилээд олноор дэлгэрсэн бөгөөд Монгол ардын хөгжмийн зэмсгийн нэгэн төрөл зүйл болох цуур хөгжим нь эгшиг үүсгэх арга зүйн хувьд хөгжмийн зэмсгийн анхны төлөв гэж үзэж болно. Тийм учраас цуур хөгжмийг Монголчуудын нүүдлийн амьдралын онцлогийг тусгасан монгол үндэсний хөгжмийн өвөг мөн гэж үзэх үндэстэй. Тэгэхдээ эгшиглэж байгаа ая аялгууны бүтэц, аяны хөдөлгөөн, хэмнэл, цараа зэргээрээ анхны төлөв болох уриа дуудлагатай ойр төстэй тул монгол ардын хөгжмийн үүсэл мөн хөөмэйн үүсэл үр хөврөл ч цуур хөгжимд хадгалагдан үлдсэн гэж үзэж болох юм.

НОМ ЗҮЙ

1. “Хятадын одоо үеийн толь бичиг”, Шинжъяан, 1978
2. Бадраа Ж. (1998), “Монгол ардын хөгжим”, УБ.,
3. Дулам С. (1989), “Монгол домог зүйн дүр”, УБ.,
4. Эрдэнэчимэг Л. (2002), “Гүн гэрийн хатагтайн “Нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу”, УБ.,
5. “Хятадын хөгжмийн зэмсэг”, Бээжин, 2005
6. “Монгол дуу хөгжмийн судлал”, Шинжъяан, 1997
7. Гэрэлт Э. (2003), “Хөөмэйн урлагийн үүсэлт тархалт”, Өвөр монголын Их сургуулийн ЭШБ,
8. Мэргэжих Ф. (1986), “Хоолойн цуурын нууц”, Талын дуулал сэтгүүл, Хөх хот,
9. “Цоорын үзэгдэл болон цоорын хөгжим”, Шанхайн хөгжмийн дээд сургуулийн ЭШБ, 1998
10. Мэргэжих Ф. (1998), “Цоорын үзэгдэл болон цоорын хөгжим”, Шанхайн хөгжмийн дээд сургуулийн ЭШСэтгүүл.